



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/02/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.open.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn
Архангай аймаг 2025 он	Аудитор В.Цогжаргал Утас: 99158257 Цахим хаяг: Tsojargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	1
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт	8
3.2 Албан шаардлага	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.21 № 151
танай _____-ны № _____-т

“АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ю.ГАНЗОРИГ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангай АЗЗА ТӨХК”-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тус компани нь байгууллагын ажилчид болон бусад хувь хүнээс нийт 181,000.0 мянган төгрөгийн богино хугацаатай зээл авч арилжааны банкны харилцах дансанд “түрээсийн орлого” гэж гүйлгээ хийлгэн, орлогоор бүртгэж тайлагнасан байна.
2. Тайлант хугацаанд дансны өглөг 318,591.8 мянга, татварын өглөг 45,733.3 мянга нийт 364,325.1 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 2009 онд Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлээр авсан машин механизм, тоног төхөөрөмжийн үнэ 198,657.6 мянган төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1, 13.1, 13.7, 14.4, 20.2.3, 20.2.9 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5 дахь заалт, Компанийн дүрмийн 4.2.7.8, 4.3.2 заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Авто замын засвар арчлалтын төрийн өмчит компаниудын хувьцаа эзэмших эрхийг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК хэрэгжүүлэх болсон тул ТӨБЗГ-

ын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 153 дугаар тогтоолоор Архангай АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зогсоож, зөвлөлийн гишүүдийг чөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 790 дүгээр тогтоолоор “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 23,619.2 мянган төгрөгийн ашигтай ажиллагаагаар баталснаас гүйцэтгэлээр 8,984.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

ТӨБЗГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор Архангай АЗЗА ТӨХК-ийн 2023 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин болон гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “сайн” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ		
1.1.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	98,857,305.32	41,553,242.50
1.1.2. Дансны авлага	0.00	12,287,727.27
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	8,644,730.33	0.00
1.1.6. Бараа материал	557,042,713.88	803,927,856.52
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	664,544,749.53	857,768,826.20
1.2.1 Үндсэн хөрөнгө	829,754,923.66	931,519,949.90
1.2.2 Биет бус хөрөнгө	47,341,600.00	50,341,600.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	877,096,523.66	981,861,549.90
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,541,641,273.19	1,839,630,376.19
2.1.1.1 Дансны өглөг	73,632,798.90	318,591,838.69
2.1.1.2 Цалингийн өглөг	-1.60	0.00
2.1.1.3 Татварын өр	17,274,991.82	45,733,348.51
2.1.1.4 НДШ-ийн өр	10.60	0.00
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	90,907,799.72	364,325,187.20
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	198,657,551.00	198,657,551.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	198,657,551.00	198,657,551.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	289,565,350.72	562,982,738.20
2.3 Эздийн өмч	971,338,586.80	971,338,586.80
2.3.1 Төрийн	971,338,586.80	971,338,586.80
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	105,238,307.65	124,888,307.65
2.3.9 Хуримтлагдсан ашиг	175,499,028.03	180,420,743.55
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,252,075,922.48	1,276,647,637.99
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,541,641,273.20	1,839,630,376.19

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	3,111,694,250.92	2,034,960,475.38
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,811,023,962.84	1,658,048,401.05
3. Нийт ашиг (алдагдал)	300,670,288.08	376,912,074.33
10. Ерөнхий ба удирдлагын зардал	262,632,392.95	366,928,834.87
12. Бусад зардал	7,940,148.00	
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	30,097,747.14	9,983,239.47
19. Орлогын татварын зардал	3,009,774.71	998,323.94
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	27,087,972.43	8,984,915.51
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	27,087,972.43	8,984,915.51
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	27,087,972.43	8,984,915.51

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	971,338,586.80	105,238,307.65	175,499,028.03	1,252,075,922.48
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	8,984,915.52	8,984,915.52
3	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	-4,063,200.00	-4,063,200.00
4	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	19,650,000.00	0.00	19,650,000.00
5	2025 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	971,338,586.80	124,888,307.65	180,420,743.56	1,276,647,638.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	3,345,716,696.50	2,136,903,924.55
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,345,716,696.50	2,136,903,924.55
1.2 Мөнгөн зарлагын дүн	3,258,834,595.51	2,080,844,787.37
Ажиллагчдад төлсөн	455,877,656.80	735,306,301.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	150,611,231.93	158,150,419.49
Бараа материал худалдан авахад төлсөн	2,020,129,229.27	481,343,573.94
Ашиглалтын зардал төлсөн	2,632,677.74	4,758,485.05
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	493,850,661.00
Татварын байгууллагад төлсөн	192,499,910.77	148,757,367.34
Даатгалын төлбөрт төлсөн		2,599,500.00
Бусад мөнгөн зарлага	433,111,842.00	56,078,479.55
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	90,854,147.99	56,059,137.18
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	109,300,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	106,000,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	3,300,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	-109,300,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Мөнгөн орлогын дүн	0.00	181,000,000.00
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	181,000,000.00
Мөнгөн зарлагын дүн	0.00	185,063,200.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	181,000,000.00
Төлсөн ногдол ашиг	0.00	4,063,200.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	-4,063,200.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	90,854,174.99	-57,304,062.82
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,003,130.33	98,857,305.32
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,857,305.32	41,553,242.50

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Х/н	2023 оны гүйцэтгэл	2024 оны	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт		382	382	382
	Нийт орлого	мян.төг	3,111,694.2	1,948,397.2	1,799,559.9
	Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	мян.төг	0.0	100,000.0	92,807.0
	Орон нутгийн чанартай зам гүүрний ажил	мян.төг	0.0	60,000.0	142,593.5
	Бусад	мян.төг	3,111,694.2	2,108,397.2	2,034,960.4
2	Нийт зардал	мян.төг	3,081,596.5	2,082,153.6	2,024,977.2
	Үүнээс удирдлагын зардал	мян.төг	262,632.3	367,789.4	366,928.8
	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	7,940.1	0.00	0.00
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	30,097.7	26,243.6	9,983.2
4	Цэвэр ашиг/алдагдал/	мян.төг	27,087.9	23,619.2	8,984.9
5	Төсвийн төлбөр шимтгэл	мян.төг	524,340.6	484,569.3	306,907.7
	Орлогын татвар	мян.төг	3,009.7	4,300.0	998.3
	НӨАТ	мян.төг	305,599.7	220,854.0	111,344.2
	НДШ	мян.төг	150,611.2	208,232.6	158,150.4
	ХХОАТ	мян.төг	32,590.8	49,875.9	30,093.8
	ҮХЭХАТ	мян.төг	1,306.8	1,306.8	1,306.8
	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	1,389.3	1,389.3	1,389.3
	Бусад татвар	мян.төг	29,833.1	90.4	3,624.9
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	0.0	11,809.6	4,063.2
7	Нийт ажиллагсдын тоо	мян.төг	37.0	37.0	37.0
8	Нийт цалингийн сан	мян.төг	433,173.2	800,894.9	737,490.0
	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	975.6	1,803.9	1,661.0
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	мян.төг	0.98	0.98	0.99
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	75,000.0	110,000.0	99,909.0
11	Нийт авлага	мян.төг	8,644.7	10,345.5	12,287.7
12	Нийт өглөг	мян.төг	289,565.3	199,756.8	562,982.7
	Богино хугацаат ер төлбөр	мян.төг	90,907.8	1,099.3	364,325.1
	Урт хугацаат ер төлбөр	мян.төг	198,657.5	198,657.5	198,657.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 207,506.7 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

Тайлант онд ажилчид болон хувь хүнээс зээлж, буцаан төлсөн 181,000.0 мянган төгрөгийг түрээсийн орлого гэж буруу тайлагнасан, 26,507.6 мянган төгрөгийн зардлыг санхүүгийн программд дутуу бүртгэснийг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.1, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 760,617.2 мянган төгрөгийн зөрчил² илэрч 3,063.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 757,553.6 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 760,617.2 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 23,719.5 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тус байгууллагын захирлын 2024 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн "Ажилчдын үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн батлах тухай" Б/22 дугаар тушаалаар албан хаагчдад 5-9 сард 20 хувийн нэмэгдэл урамшуулал олгосон байна. Тус тушаалыг үндэслэн захирал өөртөө 3,063.6 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "Сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Тус компани нь ажилчид болон хувь хүнээс 181,000.0 мянган төгрөгийн богино хугацаатай зээл авсныг бусад мөнгөн орлогоор тайлагнаж нийт орлогыг нэмэгдүүлснийг аудитын явцад залруулсан бөгөөд арилжааны банкны харилцах дансанд “түрээсийн орлого” гэж гүйлгээ хийлгэж, орлогоор бүртгэж тайлагнан анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө, 5 дугаар зүйлийн 5.1.4. Үнэн зөв байх, 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, 20.2.9.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, Компанийн дүрмийн 4.3.2-т “Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэмд заасан үүргийг биелүүлж, компанийнхаа төлөө үнэнч шударгаар ажиллана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.2.2 Тайлант хугацаанд дансны өглөг 318,591.8 мянга, татварын өглөг 45,733.3 мянга нийт 364,325.1 мянган төгрөгийн богино хугацаат, 2009 онд Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлээр авсан машин механизм, тоног төхөөрөмжийн үнэ 198,657.6 мянган төгрөгийн урт хугацаат өр төлбөртэй тайлагнагдсан бөгөөд санхүүжилтийн эх үүсвэр байхад дээрх өр төлбөрийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх”, Компанийн дүрмийн 4.2.7 Гүйцэтгэх захирал ньдүрэмд заасан үүрэг хүлээж эрх эдэлнэ, 4.2.7.8 Компанийн ажлын гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бизнесийн болон худалдан авалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж, зохих арга хэмжээ авах гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, өр төлбөрийн барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.2.3 Аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн Б/31 дүгээр захирамжийг үндэслэн гүйцэтгэх захиралд 3,870.9 мянган төгрөгийн тэтгэмж, урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "Сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.2.4 Албан томилолтоор ажилласныг нотлох баримтын бүрдэл дутуу, анхан шатны баримтгүй 9,700.0 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн орлогыг нотлох анхан шатны баримт байхгүй	1	181,000.0			1	181,000.0
Тайлант хугацаанд өр төлбөртэй тайлагнагдсан	1	562,982.7			1	562,982.7
Захирал өөртөө тушаал гарган урамшуулал авсан	1	3,063.6	1	3,063.6		
Захиралд аймгийн ЗД-ын захирамжийг үндэслэн тэтгэмж урамшуулал олгосон.	1	3,870.9			1	3,870.9
Албан томилолтоор ажилласныг нотлох баримтын бүрдэл дутуу, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн.	1	9,700.0			1	9,700.0
Нийт дүн	5	760,617.2	1	3,063.6	4	757,553.6